ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2025/01/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2025 он	Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70592225 Цахим хаяг: Oyun-erdenet@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Ихбаяр Утас: 70593113 Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан 4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан 4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл 5
3. Аудитын илрүүлэлт 5
3.1 Албан шаардлага 6
3.2 Өгсөн зөвлөмж: 6
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайншагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.03.24 № 81

танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ-УС ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Т.МӨНХБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын батлсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дундговь-Ус ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тээвэр шатахууны зардлын зарцуулалтын тооцоог бодож баталгаажуулаагүй, хяналтгүй зарцуулсан нь залруулах боломжгүй материаллаг зөрчил байна. Залруулагдаагүй зөрчил нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 29.5 сая төгрөгөөр буюу 1.6 дахин их, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1-р хавсралтад заасан заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 12,414.5 сая төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 11,072.2 сая төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр баригдсан цэвэрлэх байгууламжийг дуусаагүй барилгаас барилга, байгууламжийн данс руу шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 3,902.4 сая төгрөгөөр буурсан нь орон нутгийн төсвөөс Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр баригдсан цэвэрлэх байгууламжийн зээлийг төлсөнтэй холбоотой байна.

Цалингийн зардал өмнөх оноос 38.0 хувиар өссөн нь Төлөөлөн удирдах зөвлөлийн

4825929279

шийдвэрээр 2024 оны 05 дугаар сарын 01-ээс төрийн албан хаагчдын үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой. Уг үйл явдлыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тээвэр шатахууны зардлын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, 71.8 сая төгрөгийн төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	44,572,702.03	41,527,378.68
1.1.02	Дансны авлага	269,613,544.95	324,936,080.33
1.1.06	Бараа материал	13,264,604,387.10	850,152,593.33
1.1.11	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**13,578,790,634.08**	**1,216,616,052.34**
1.2.01	Үндсэн хөрөнгө	33,402,064,177.02	44,474,284,684.39
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	33,402,064,177.02	44,474,284,684.39
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**46,980,854,811.10**	**45,690,900,736.73**
2.1.1.01	Дансны өглөг	229,685,830.50	582,347,683.20
2.1.1.03	Татварын өр	133,895,450.66	335,036,596.70
2.1.1.04	НДШ - ийн өглөг	51,691,894.94	6,248,297.06
2.1.1.13	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**415,273,176.10**	**923,632,576.96**
2.1.2.01	Урт хугацаат зээл	15,075,963,944.05	11,173,537,620.43
2.1.2.06	**Урт хугацаат өр төлбөрийн дүн**	**15,075,963,944.05**	**11,173,537,620.43**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**15,491,237,120.15**	**12,097,170,197.39**
2.3.02	- хувийн	24,321,432,579.22	28,091,986,395.14
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15,449,157,774.34	15,449,157,774.34
2.3.08	**Эздийн өмчийн бусад хэсэг**	**-3,835,415,924.32**	**-3,835,415,924.32**
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-4,445,556,738.29	-6,111,997,705.82
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-1,666,440,967.53
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-4,445,556,738.29	-4,445,556,738.29
2.3.11	**Эздийн өмчийн дүн**	**31,489,617,690.95**	**33,593,730,539.34**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**46,980,854,811.10**	**45,690,900,736.73**

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	**Борлуулалтын орлого (цэвэр)**	**1,701,057,702.63**	**2,690,444,226.38**
02	**Борлуулалтын өртөг**	**3,688,908,615.26**	**4,887,209,912.06**
03	**Нийт ашиг(алдагдал)**	**-1,987,850,912.63**	**-2,196,765,685.68**
08	Бусад орлого	533,412,155.88	801,060,061.62
08.1	**Орлогын дүн**	**533,412,155.88**	**801,060,061.62**
10	Ерөнхий ба удирдлагын зардал	200,351,545.06	270,735,343.47
12.1	**Зардлын дүн**	**200,351,545.06**	**270,735,343.47**
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-27,582,962.57	0.00
17.1	Олз, гарзын дүн	-27,582,962.57	0.00
18	**Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)**	**-1,682,373,264.38**	**-1,666,440,967.53**
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	**Татварын дараах ашиг (алдагдал)**	**-1,682,373,264.38**	**-1,666,440,967.53**
22	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**-1,682,373,264.38**	**-1,666,440,967.53**

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	**2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл**	**23,883,924,070.10**	**15,449,157,774.34**	**-3,835,415,924.32**	**-2,763,183,473.91**	**32,734,482,446.21**
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-1,682,373,264.38	-1,682,373,264.38

06	Өмчид гарсан өөрчлөлт	437,508,509.12	0.00	0.00	0.00	437,508,509.12
09	**2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл**	**24,321,432,579.22**	**15,449,157,774.34**	**-3,835,415,924.32**	**-4,445,556,738.29**	**31,489,617,690.95**
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-1,666,440,967.53	-1,666,440,967.53
14	Өмчид гарсан өөрчлөлт	3,770,553,815.92	0.00	0.00	0.00	3,770,553,815.92
17	**2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл**	**28,091,986,395.14**	**15,449,157,774.34**	**-3,835,415,924.32**	**-6,111,997,705.82**	**33,593,730,539.34**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**2,294,616,406.29**	**3,571,613,074.86**
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,839,731,176.29	2,851,627,074.86
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	719,986,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	454,885,230.00	0.00
1.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**2,276,772,477.28**	**3,544,642,698.21**
1.2.1	Ажиллагчдад төлсөн	755,282,558.88	924,960,074.24
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	70,787,796.95	331,459,574.41
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	206,441,434.00	1,267,038,774.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	297,163,729.37	367,072,585.74
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	593,508,003.00	239,168,866.50
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	86,654,584.19	103,078,657.69
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	150,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	266,934,370.89	311,714,165.63
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	17,843,929.01	26,970,376.65
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	30,015,700.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	30,015,700.00
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**0.00**	**-30,015,700.00**
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	17,843,929.01	-3,045,323.35
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**26,728,773.02**	**44,572,702.03**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**44,572,702.03**	**41,527,378.68**

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Борлуулалтын орлого	2,967,571,400.00	3,491,504,288.00	-523,932,888.00	117.7
2	ББӨ	5,398,485,800.00	4,887,209,912.06	511,275,887.94	90.5
3	Нийт ашиг	-2,780,534,900.00	-1,666,440,967.53	-1,114,093,932.47	59.9
4	Ерөнхий удирдлагын зардал	349,620,500.00	270,735,343.47	78,885,156.53	77.4
5	Цалингийн сан	1,141,393,400.00	1,125,308,121.40	16,085,278.60	98.6

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 291,962.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 4,856.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 156,172.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 130,933.5 мянган төгрөгийн 3 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

Залруулсан алдаа:

Аудитаар 4,856.1 мянган төгрөгийн дараах алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Үүнд:

1. Нийгмийн даатгалын тайланд даатгуулагчийн цалин хөлсийг тайлагнаагүйтэй холбоотой 4,856.1 мянган төгрөгийн алданги төлбөрийг байгууллагын төсвөөс төлснийг авлагаар тайлагнуулсан.

Залруулаагүй алдаа:

Аудитаар нийт 287,106.0 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 156,172.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 130,933.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

3.1.1. Тээвэр шатахууны зардлын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, 71,835.7 төгрөгийн шууд худалдан авалт хийсэн.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4.-т /хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох;/, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т /Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно./, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтын 1–т /Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар нь бараа, ажил, үйлчилгээний хувьд – 20.0 сая/ заасныг;

3.1.2 Албан хэрэгцээнд зарцуулсан 81,118.6 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардлын зарцуулалтын тооцоог бодож баталгаажуулаагүй, хяналтгүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.2 /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. /Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат, дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна/, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1-р хавсралтад /Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг үндэслэн тогтоож, мөрдөж ажиллах, шатахууны зарцуулалтын тооцоог тогтсон хугацаанд бодож, тооцоо бодсон актыг үйлдэж баталгаажуулах/ заасныг;

3.1.3 Нийгмийн даатгалын тайланд даатгуулагчийн кодыг буруу оруулж, зардлыг 3,218.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1-д /Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;/ заасныг тус зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

3.2.1. Хөрөнгийн данстай холбоотой.

Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 42 нэр төрлийн 129,588.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6./эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/; ТӨБЗГ-ын 2019 оны

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

271 дүгээр тогтоолоор батлсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д /Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ/ заасныг, мөн тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Журамд заасны дагуу хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгүүдийг шийдвэрлүүлж, хариуг нотлох баримтын хамт Дундговь аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 06 дугаар сарын 20-ний дотор ирүүлэх.

3.2.2 Зардлын данстай холбоотой.

Илрүүлэлт:

Сахилгын шийтгэлтэй албан хаагчийн суутгалыг буруу тооцож, зөрүүтэй тайлагнасан

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. /үнэн зөв байх/, 20.2.4.-т /нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;/, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3-т /үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. /үнэн зөв байх/, 20.2.4.-т /нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;/ заасныг, мөн үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ажилтны сахилгын шийтгэлийн суутгалыг хууль журмын дагуу тооцож нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөх, хариуг нотлох баримтын хамт Дундговь аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 06 дугаар сарын 20-ний дотор ирүүлэх

3.2.4 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой.

Шилэн дансны цахим хуудсанд Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн /Шилэн дансны зарчим/ 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; /, 6 дугаар зүйлийн 6.4-т /Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:/ заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг таслан зогсоож төсвийн зарцуулалттай холбоотой мэдээллийг цахим хуудсанд, хуулиар тогтоосон хугацаанд байршуулж цаашид Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах; хариуг нотлох баримтын хамт Дундговь аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 25-ний дотор ирүүлэх.

Дээрх зөвлөмж нь тус байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлан хийсэн завсрын аудитаар өгөгдсөн бөгөөд хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын тайланд даатгуулагчийн цалин хөлсийг тайлагнаагүйтэй холбоотой алданги төлбөрийг байгууллагын төсвөөс төлсөн.	1	4,856.05	1	4,856.1			1	4,856.1				
Дүн		**4,856.05**	**1**	**4,856.05**			**1**	**4,856.05**				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын тайланд даатгуулагчийн кодыг буруу оруулж, зардлыг дутуу тайлагнасан.	1	3,218.2			1	3,218.2						
Тээвэр шатахууны зардлын зарцуулалтын тооцоог хууль журмын дагуу бодож баталгаажуулаагүй, хяналтгүй зарцуулсан.	1	81,118.6			1	81,118.6						
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 42 нэр төрлийн үндсэн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй.	1	129,588.0					1	129,588.0				
Сахилгын шийтгэлтэй албан хаагчийн суутгалыг буруу тооцож, зөрүүтэй тайлагнасан	1	1,345.49					1	1,345.5				
Дүн	**4**	**215,270.3**			**2**	**84,336.8**	**2**	**130,933.5**				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны цахим хуудсанд Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-				
Дүн	1	-					1					
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Тээвэр шатахууны зардлын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн.	1	71,835.7			1	71,835.7	-	-				
Дүн	**1**	**71,835.7**			**1**	**71,835.7**						
Нийт дүн	**2**	**71,835.7**			**1**	**71,835.7**	**1**	**-**				